



**2020**

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



# Үйл ажиллагааны тайлан



## ТОП-20 индексд багтав

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексд багтав



## Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар Э.Амарбаясгалан томилогдлоо



## Гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Ард Секюритиз ҮЦК гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авав



# Үйл ажиллагааны тайлан



---

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал


Ард Санхүүгийн Нэгдэл (AARD), Ард Даатгал (AIC), Ард Кредит (ADB) хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 64.8%, 88.1%, 85.2% ирцтэйгээр тус тус онлайнаар зохион байгуулав



---

## Нэмэлт хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Лайфд 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийв



---

## Цахим мөнгөний зөвшөөрөл

Монголбанкнаас Ард Кредитэд цахим мөнгөний зөвшөөрөл олгов

# Үйл ажиллагааны **тайлан**



---

## Ногдол ашгаа хуваарилав


Ард Санхүүгийн Нэгдэл (AARD), Ард Даатгал (AIC), Ард Кредит (ADB) ногдол ашгаа хуваарилав



---

## Анхны хөрөнгө оруулалтын сан

Ард Менежмент нь анхны хөрөнгө оруулалтын санг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүллээ



---

## Нээлттэй бонд

Нээлттэй бонд гаргах хүсэлтээ МХБ болон СЗХ-д хүргүүлэв



# Үйл ажиллагааны тайлан



---

## Хөрөнгө Оруулагч Үндэстэн Европ болон хөдөө орон нутагт

Хөрөнгө Оруулагч Үндэстэн уулзалтыг Европын улсуудад болон хөдөө орон нутагт амжилттай зохион байгуулж ажиллаж байна



---

## Хувьцаатай хүүхэд Ирээдүйн Эзэд

Хувьцаатай хүүхэд-Ирээдүйн эзэд аянг амжилттай эхлүүлэв



# Ард Аппын хөгжүүлэлт

Апп хувилбар 3.0 гаргасан

Олон улсын дугаараар бүртгэл хийх боломжтой болсон


Даатгалын функц нэмсэн

Долларын валютаар гүйлгээ хийх боломжтой болсон

CASPO буюу үнэт цаасны арилжаа хийгдэх боломжтой болсон

IPO, бонд захиалгад оролцох боломжтой болсон

Цахим мөнгөний зөвшөөрөлтэй холбоотой Ard cash бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн.





# Бидний ойрын ирээдүй

## Ард Лайф

Шинээр өргөн барьсан “Хувийн тэтгэврийн сангийн тухай” хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авах

Шинэ стратегийн хөрөнгө оруулагчдыг татан оруулж ирэх

Олон нийтэд хувьцааг нь санал болгох

## Ард Даатгал

Даатгалын зах зээл дээрх нэгдэл, нийлэх боломжийг эрэлхийлэх

Амьдралын даатгалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг байгуулах

## Ард Кредит

Зээл авах боломжийг бид хөдөө орон нутгийн иргэдэд нээх

Гадаадад суугаа Монголчуудаа хамруулж ажиллах

Арилжааны банк буюу банкны нэгдэлтэй хамтын ажиллагааны түншлэлийг үүсгэж, харилцан ашигтай бизнесийн загварыг санаачилж ажиллана

# Бидний ойрын ирээдүй

## Монголын Хөрөнгийн Бирж

Нээлттэй бондоо Монголын зах  
зээл дээр гаргах

Гадаадын хувьцаанд  
хөрөнгө оруулах боломжийг  
харилцагчдадаа олгох

## The Apprentice Mongolia

The Apprentice бизнесийн реалити  
шоуг Монгол улсад Монгол HD  
телевиз албан ёсны эрхтэйгээр  
зохион байгуулах болсон ба уг шоу  
нэвтрүүлгийг Гүйцэтгэх захирал  
Ч.Ганхуяг шүүн явуулахаар боллоо



## **Хувьцаа эзэмшигчдийн ЭЭЛЖИТ ХУРАЛ**

2020 оны эхний хагас жилд дэлхий дахинаа шинэ КОВИД-19 (COVID-19)-ын халдвар эрчимтэй тархаж, УОК-оос улс орон даяар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон энэ үед Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахимаар ([live.ard.mn](http://live.ard.mn)) амжилттай зохион байгууллаа.

Хуралд нийт 12,878,762 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож, 64.76 хувийн ирцтэйгээр хуралдан Компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталлаа.







# Төлөөлөн Удирдах Зөвлөл

## ТУЗ-ийн дарга



**Пүрэвжаргалын Батбаяр**  
(ТУЗ-ийн дарга,  
Ард Санхүүгийн Нэгдэл)

## Ердийн гишүүд



**Чулууны Ганхуяг**  
(Гүйцэтгэх захирал,  
Ард Санхүүгийн Нэгдэл)



**Бруно Рашле**  
(Дэд дарга,  
Шродер Адвек)



**Авир Сүхдорж**  
(БСБ Сервис, ГрэйпСити  
Монгол, МОСТ Финтек  
компаниудын үүсгэн  
байгуулагч)



**Майнбаярын Тулгат**  
(Гүйцэтгэх захирал,  
Биг Платформ ХХК)



**Одончимэдийн Одбаяр**  
(Ард Даатгал ХК-ийн  
ТУЗ-ийн гишүүн)

## Хараат бус гишүүд



**Чулууны Мөнхбат**  
(Ерөнхийлөгч,  
Саусгоби сэндс)



**Мөнх-Очирын Сэргэлэн**  
(Ерөнхийлөгч,  
Техник Технологийн ДС)



**Михаил Зелдович**  
(Хяналтын зөвлөлийн  
дарга, Кокуун капитал)



**Арно Вентура**  
(Үүсгэн байгуулагч,  
Баоаб Групп)





# Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороод



## Дотоод аудитын хороо

- 1.ТУЗ-ийн хараат бус гишүүн Чулуун Мөнхбат /Хорооны дарга/
- 2.ТУЗ-ийн ердийн гишүүн Авир Сүхдорж
- 3.ТУЗ-ийн хараат бус гишүүн Мөнх-Очир Сэргэлэн

## Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

- 1.ТУЗ-ийн ердийн гишүүн Одончимэд Одбаяр /Хорооны дарга/
- 2.ТУЗ-ийн хараат бус гишүүн Мөнх-Очир Сэргэлэн
- 3.ТУЗ-ийн хараат бус гишүүн Михаил Зелдович

## Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо

- 1.ТУЗ-ийн хараат бус гишүүн Арно Вентура /Хорооны дарга/
- 2.ТУЗ-ийн ердийн гишүүн Чулуун Ганхуяг
- 3.ТУЗ-ийн ердийн гишүүн Бруно Рашле



# ТУЗ-ийн тайлан

## ТУЗ-ийн хурал

Ээлжит хурал 2 удаа  
Ээлжит бус хурал 3 удаа

## Хэлэлцсэн асуудал

40

## Хороодын хурал

Хөрөнгө оруулалт,  
санхүү, эрсдэлийн хороо 2 удаа  
Аудитын хороо 2 удаа  
Засаглал, нэр  
дэвшүүлэх, цалин  
урамшууллын хороо 3  
удаа

## Гаргасан шийдвэр

24

## Гол шийдвэр:



Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай Ард Бит ХХК-ийн бүх хувьцааг хувьцаанд хамаарах эрх, үүргийн хамт И Ай Ти ХХК-д худалдах шийдвэр гарав.



2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилав.



Нээлттэй өрийн бичиг гаргах шийдвэр гаргав.



Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлав.



Гүйцэтгэх захирлын 2020 оны KPI батлав.



Ард Менежмент ҮЦК ХХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхийг батлав.





## Удирдлагын баг



**Чулуун ГАНХУЯГ**  
Гүйцэтгэх захирал



**Жаргалан АЛТАНГҮНИЙ**  
Үйл ажиллагаа хариуцсан захирал



**Гарьд ТЭНҮҮН**  
Дижитал технологийн захирал



**Батбилэг ЗОЛБОО**  
Санхүү эрхэлсэн захирал



**Баяраа АРИУНАА**  
Маркетинг хариуцсан захирал



**Энхсайхан АМАРБАЯСГАЛАН**  
Хөрөнгө оруулалт хариуцсан захирал



**Мөнхбат МӨНХ-ЭРДЭНЭ**  
Дотоод аудитор



**Сүхбаатар АНАР-ЭРДЭНЭ**  
Хууль эрх зүй, хянан нийцүүлэлт эрхэлсэн захирал



**Баярсайхан ОЮУТЦЭЦЭН**  
Эрсдэлийн менежер



**Аръясүрэн БАТБОЛД**  
Байгууллагын нарийн бичгийн дарга



**Хангай ХУЛАН**  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

#	Хувьцаа эзэмшигч	12/31/2019	хувь	6/30/2020	хувь
1	Ард Бит	4,243,090	14.83%	4,016,091	14.04%
2	Ард Холдингс Интернэшнл	2,874,410	10.05%	2,874,410	10.05%
3	Хишигдорж Батхишиг	2,657,214	9.29%	2,657,214	9.29%
4	Бруно Рашле	2,074,922	7.25%	2,098,592	7.33%
6	Галням Уянга	1,330,147	4.65%	1,333,147	4.66%
8	Чулуун Ганхуяг	1,239,374	4.33%	1,239,374	4.33%
9	Ард Лайф	1,365,018	4.77%	1,486,435	5.19%
10	Ард Секюритиз	1,007,392	3.52%	1,024,257	3.58%
11	Авир Сүхдорж	536,417	1.87%	563,155	1.97%
12	Ронк Лимитэд	479,111	1.67%	479,111	1.67%
13	Сэдбазар Гэрэлтуяа	455,717	1.59%	455,717	1.59%
14	Ард Даатгал	435,362	1.52%	417,905	1.46%
15	И Ай Ти	331,253	1.16%	331,253	1.16%
17	Лхагвасүрэн Соронзонболд	315,069	1.10%	315,069	1.10%
18	Масик Энтерпрайзес	269,483	0.94%	269,483	0.94%
	<b>Топ 15 хувьцаа эзэмшигчид</b>	<b>19,613,979</b>	<b>68.55%</b>	<b>19,561,213</b>	<b>68.36%</b>
	<b>Бусад хувьцаа эзэмшигчид</b>	<b>7,585,578</b>	<b>26.51%</b>	<b>7,638,344</b>	<b>26.69%</b>
	<b>Эргэлтэнд байгаа хувьцаа</b>	<b>27,199,557</b>	<b>95.06%</b>	<b>27,199,557</b>	<b>95.06%</b>
	<b>Халаасны хувьцаа</b>	<b>1,414,706</b>	<b>4.94%</b>	<b>1,414,706</b>	<b>4.94%</b>
	<b>Нийт гаргасан хувьцаа</b>	<b>28,614,263</b>	<b>100%</b>	<b>28,614,263</b>	<b>100%</b>
	<b>Хувьцаа эзэмшигчид</b>	<b>4,063</b>		<b>4,274</b>	





# Хувьцааны арилжаа

MSE: 

AARD арилжааны график (2019.8.8 - 2020.6.30)



<b>Нээлт</b>	₮1,911
<b>52 долоо хоногийн доод</b>	₮1,200
<b>52 долоо хоногийн дээд</b>	₮2,090
<b>Хаалт</b>	₮1,299

<b>Арилжааны дүн</b>
<b>Зах зээлийн үнэлгээ</b>
<b>Үнэ/Ашиг (ТТМ)</b>
<b>Үнэ/Дансны үнэ</b>

Жилд - ₮5.1 тэрбум
Хагас жилд - ₮2.2 тэрбум
₮37.17 тэрбум
6.2
0.7







# Гол үзүүлэлт



Нийт хөрөнгө  
(сая төгрөг)



Нийт өр төлбөр болон эздийн өмч  
(сая төгрөг)







# Гол үзүүлэлт



Нийт дэлгэрэнгүй орлого  
(сая төгрөг)



Нийт үнэлгээ  
(сая төгрөг)





# Орлогын тайлан

(мянган төгрөг)	2019.II	2019.IV	2020.I	2020.II	Жилийн өсөлт
Хөрөнгө оруулалтын орлого	139,368	9,374,379	1,794,383	1,794,383	1188%
Хүүний орлого	147,586	304,891	18,579	30,862	-79%
Ногдол ашгийн орлого	483,442	537,157	0	1,346,630	179%
Түрээсийн орлого	358,513	716,857	196,991	383,155	7%
Менежментийн орлого	172,066	346,333	202,385	368,776	114%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,300,975</b>	<b>11,279,617</b>	<b>2,212,338</b>	<b>3,923,806</b>	<b>202%</b>
Цалингийн зардал	393,506	1,150,515	247,289	836,971	113%
Үйл ажиллагааны зардал	2,380,866	4,661,493	532,323	1,303,903	-45%
Санхүүгйн зардал	553,572	1,479,681	214,656	782,740	41%
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>3,327,944</b>	<b>7,291,689</b>	<b>994,268</b>	<b>2,923,614</b>	<b>-12%</b>
Бусад ашиг (алдагдал)	246,410	407,907	29,320	37,279	-85%
Гадаад валютын ханшийн зөрүү олз (гарз)	-550	-20,036	-55,163	-125,648	-22745%
<b>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ</b>	<b>-1,781,109</b>	<b>4,375,799</b>	<b>1,192,227</b>	<b>911,823</b>	<b>151%</b>
Орлогын албан татварын зардал	14,759	970,978	119,223	134,666	812%
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>-1,795,868</b>	<b>3,404,821</b>	<b>1,073,004</b>	<b>777,157</b>	<b>143%</b>



## Баланс

(мянган төгрөг)	2019 У.II	2019.IV	2020.I	2020.II	Жилийн өсөлт	Оны эхнээс	Улирлын өсөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	702,057	43,236	26,144	185,354	-74%	329%	609%
Худалдааны ба худалдааны бус авлага	859,553	4,918,999	7,278,666	7,107,150	727%	44%	-2%
Олгосон зээл	5,337,937	400,000	400,000	0	-100%	-100%	-100%
Урьдчилж төлсөн зардал	5,833,409	3,685,467	3,680,302	3,760,496	-36%	2%	2%
Үндсэн хөрөнгө	896,513	642,007	587,779	1,290,608	44%	101%	120%
Борлуулахаар эзэмшиж буй хөрөнгө	5,001,656	0	0	0	-100%	100%	0%
Биет бус хөрөнгө	11,742	127,431	122,712	117,992	905%	-7%	-4%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	398,213	16,506	16,711	16,994	-96%	3%	2%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	53,836,872	68,238,169	64,854,340	60,828,970	13%	-11%	-6%
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>72,877,952</b>	<b>78,071,815</b>	<b>76,966,654</b>	<b>73,307,564</b>	<b>1%</b>	<b>-6%</b>	<b>-5%</b>
Худалдааны ба худалдааны бус өглөг	477,050	1,172,621	1,046,984	354,480	-26%	-70%	-66%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,316,514	3,196,371	2,716,371	2,082,372	-10%	-35%	-23%
Татварын өр	57,569	66,083	279,933	247,641	330%	275%	-12%
Урьдчилж орсон орлого	0	12,902	12,902	70,738	100%	448%	448%
Бусад өр төлбөр	375,452	1,362,072	1,293,023	1,519,311	305%	12%	18%
Урт хугацаат өр төлбөр	8,195,528	12,608,574	14,029,059	16,257,048	98%	29%	16%
Хойшлогдсон татварын өр	3,035,443	3,070,863	2,757,082	1,951,649	-36%	-36%	-29%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,457,556</b>	<b>21,489,486</b>	<b>22,135,354</b>	<b>22,483,239</b>	<b>56%</b>	<b>5%</b>	<b>2%</b>
Энгийн хувьцаа	1,719,436	27,175,629	27,175,629	27,175,629	1480%	0%	0%
Нэмж төлөгдсөн капитал	9,929,061	0	0	-	100%	100%	0%
Дахин үнэлгээний нэмэгдэл	23,786,701	16,124,513	13,300,480	10,589,419	-55%	-34%	-20%
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799	13,799	13,799	0%	0%	0%
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	22,971,401	13,268,388	14,341,393	13,045,478	-43%	-2%	-9%
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>58,420,398</b>	<b>56,582,329</b>	<b>54,831,301</b>	<b>50,824,325</b>	<b>-13%</b>	<b>-10%</b>	<b>-7%</b>



# Компанийн үнэлгээ

(мянган төгрөг)	2019 У2	2019 У4	2020 У1	2020 У2	Жилийн өсөлт	Оны эхнээс	Улирлын өсөлт
<b>Стратегийн хөрөнгө оруулалтууд</b>	<b>33,275,978</b>	<b>67,288,169</b>	<b>63,896,339</b>	<b>59,859,970</b>	<b>80%</b>	<b>-11%</b>	<b>-6%</b>
Монгол Шуудан	17,057,788	18,066,087	16,699,578	13,955,542	-18%	-23%	-16%
Хөрөнгө Оруулагч Үндэстэн	0	0	0	0	100%	100%	100%
Ард Даатгал	12,844,913	13,355,853	11,995,725	11,703,813	-9%	-12%	-2%
Ард Кредит	13,922,530	13,972,993	13,507,800	12,497,378	-10%	-11%	-7%
Ард Секюритиз	2,304,926	2,304,926	2,304,926	2,304,926	0%	0%	0%
Ард Менежмент	365,333	365,333	365,333	365,333	0%	0%	0%
Ард Актив	58,726	118,726	118,726	128,726	119%	8%	8%
Ард Лайф	2,426,041	11,426,041	11,426,041	11,426,041	371%	0%	0%
Ард Бит	200,000	200,000	0	0	-100%	-100%	100%
Тэнгэр Системс	1,153,508	1,153,508	1,153,508	1,153,508	0%	0%	0%
Ард Холдингс Интернэшнл	0	6,324,702	6,324,702	6,324,702	100%	0%	0%
<b>Стратегийн бус хөрөнгө оруулалтууд</b>	<b>3,479,995</b>	<b>950,000</b>	<b>958,000</b>	<b>969,000</b>	<b>-72%</b>	<b>2%</b>	<b>1%</b>
Номын Хишиг	1,780,000	0	0	0	-100%	100%	100%
Техник Технологийн Дээд Сургууль	749,995	0	0	0	-100%	100%	100%
Крипто Үндэстэн сан	950,000	950,000	958,000	969,000	2%	2%	1%
<b>Бусад</b>	<b>7,618,967</b>	<b>-8,584,976</b>	<b>-7,343,430</b>	<b>-8,052,996</b>	<b>-206%</b>	<b>6%</b>	<b>-10%</b>
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5,399,869	16,506	16,711	16,994	-100%	3%	2%
Үндсэн хөрөнгө	908,255	769,438	729,545	1,408,600	55%	83%	93%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	702,057	43,236	26,144	185,354	-74%	329%	609%
Цэвэр авлага	608,786	-9,414,156	-8,115,830	-9,663,944	-1687%	-3%	-19%
<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ</b>	<b>44,374,940</b>	<b>59,653,193</b>	<b>57,510,909</b>	<b>52,775,974</b>	<b>19%</b>	<b>-12%</b>	<b>-8%</b>
Эргэлтэд байгаа хувьцааны тоо	17,194,364	27,175,629	27,175,629	27,175,629	58%	0%	0%
<b>Нэгж хувьцааны үнэлгээ</b>	<b>2,581</b>	<b>2,195</b>	<b>2,116</b>	<b>1,942</b>	<b>-25%</b>	<b>-12%</b>	<b>-8%</b>



# Эрсдэлийн удирдлага



Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь удирдлагын тогтолцоо, Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ), ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо; охин компаниудын ТУЗ-ийн дэргэдэх хороодоор дамжуулан группын үйл ажиллагаанд учирч болзошгүй гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалах эрсдэлүүдийг эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу гол 8 төрлөөр ангилан тэдгээр эрсдэлээс сэргийлж, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын хамгаалалтын гурван түвшинг бүрдүүлснээр бүх түвшний ажилчид өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хариуцлагыг хүлээдэг нь нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, компанийн тогтвортой хөгжлийг хангаж буй явдал юм.

Ард Санхүүгийн Нэгдэл нь эдийн засаг, хөрөнгийн зах зээлд нөлөөлөх гадаад ба дотоод хүчин зүйлсийг тогтмол хянаж, бизнесийн стратеги төлөвлөлтийг нөхцөл байдалд уялдуулан ажилладаг. 2020 оны хувьд АНУ ба Хятад улсуудын хооронд үүсээд буй “худалдааны дайн” нь Монголын экспортод сөргөөр нөлөөлөх байдлаар эдийн засаг саарах эрсдэлийг үүсгэж байсан бол шинэ төрлийн COVID-19 тахал дэгдсэнээр Монгол төдийгүй дэлхий даяар бизнесийн үйл ажиллагаа саарч, 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас хойш үүсээгүй уналт, тогтворгүй байдал ажиглагдлаа.

Монгол улсын хувьд 2020 оны эхний улирлын байдлаар бодит ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.7 хувиар буурч, эхний хагас жилд 2.2 их наяд төгрөгийн төсвийн алдагдлыг хүлээж, төлбөрийн тэнцэл 1.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, нийт

экспортын хэмжээ 28 хувиар, импортын хэмжээ 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тус тахлаас үүдэх эрсдэлийг бууруулахаар Монголбанк бодлогын хүүг 9 хувь хүртэл буюу 2 нэгж хувиар бууруулаад байгаа бол гадаад валютын албан нөөц эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар буурч, долларын ханш жилд 6 хувиар өсжээ. Иймээс 2020 оны эхний хагас жилд Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ нь сар бүр ээлжит бусаар хурал зохион байгуулж, ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо нь шинэчилсэн эрсдэлийн бодлого, эрсдэлийг үнэлэх аргачлалууд, мөн шинэчлэн сайжруулсан мөнгө угаахтай холбоотой дотоод хяналтын хөтөлбөрийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж байна.

Ард Санхүүгийн Нэгдлийн бүх охин компаниуд аливаа учирч болзошгүй эрсдэлд бэлэн байх үүднээс бэлэн мөнгийг нөөцлөх стратеги баримталж байгаа бол Ард Кредит нь зээлийн эрсдэлийг бууруулах дээр онцгойлон анхаарч, зээлийн чанарыг сайжруулахын зэрэгцээ зээлийн эрсдэлийн санг Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагатай хэмжээнээс илүү байгуулж, үүсэж болзошгүй бүхий л сөрөг нөхцөл байдалд компанийн болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж ажиллаж байна. Мөн оны эхний хагаст Монголын хөрөнгийн зах зээл 21 хувиар унасан тул Ард Санхүүгийн Нэгдэл нь хөрөнгө оруулалтын эрсдэлд онцгой анхаарал хандуулж, бодит үнэ цэнийн тооцооллыг тогтмол гүйцэтгэж, ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороогоор тогтмол хянуулж ажиллаж байна.



Хүчтэй. Хамтдаа.